



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/616

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд Есөнзүйл сумын 3 дугаар багийн иргэн О.Ганбатад 10 га газарт малын тэжээл тариалж, эрчимжсэн аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж 2,000,000 (хоёр сая), “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төвд бэлгийн багц савлах баглаа, боодол худалдан авахад 3,500,000 (гурван сая таван зуун мянга) “Өвөрхангайд үйлдвэрлэв” үйлдвэр эрхлэгчдийн каталогийг цахимаар сурталчлахад 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 7,000,000 (долоон сая) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101311